



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 дугаар сарын 20

Дугаар 14/02

Баян-Өндөр сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, шаардагдах төсөв, хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, хөтөлбөрийн биелэлтийн явцыг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгасугай.

3.Энэхүү хөтөлбөр батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай” 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Ээлжит бус XIV хуралдааны 14/02 дугаар тогтоолын хавсралт




АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС-УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨР

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”. Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалахад оршино.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц гэж хуульчилсан байдаг.

Орхон аймгийн сүүлийн 5 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн криминологийн судалгаагаар Олон улсад гэмт хэргийн нөхцөл байдлыг тусгай шалгуурын хүрээнд индексжүүлэн дүгнэдэг бөгөөд уг индекс 20-оос доош байвал тус улсад үйлдэгдэх гэмт хэргийн гаралт нэн ховор, 20-40 бол гэмт хэргийн түвшин бага, 40-60 бол дунд, 60-80 бол өндөр, 80-аас 100 хүртэл бол гэмт хэргийн хохирогч болох магадлал хамгийн их байна гэж үздэг. Монгол Улсын хувьд тухайн статистикийн жагсаалтад энэ оны байдлаар нийт 144 орноос гэмт хэргийн индексээр 53.5 буюу “дунд”, аюулгүй байдлын индексээр 46.5 буюу мөн “дунд” үнэлгээтэйгээр 43 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Орхон аймгийн хувьд гэмт хэргийн индексээр 30.9 буюу гэмт хэргийн түвшин “бага”, аюулгүйн индексээр 69.1 буюу сайн “өндөр” үзүүлэлттэй байна.



Орхон аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл (2018-2022)




Орхон аймагт Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан залилах, хулгайлах, хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэх явдал, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих зэрэг гэмт хэрэг улсын дунджаас өндөр хувьтай цаашид анхаарч ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийжээ.

Жилд дунджаар улсын хэмжээнд 10,000 хүн тутамд 109 хүн гэмт хэрэгт холбогдсон бол Орхон аймгийн хэмжээнд 10,000 хүн тутамд 50 хүн дээрх 5 төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа ба гэмт хэрэгт холбогдогчдын 65.4 хувь нь 18-39 насныхан буюу сурч хөдөлмөрлөх насны залуучууд байх бөгөөд гэр бүлийн таарамжгүй харилцаа, архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн, хууль эрх зүйн мэдлэг дутмаг, бусадтай харилцах харилцаа, хандлага муу, иргэд тээврийн хэрэгслээр зорчихдоо хувийн эд зүйлээ хараа хяналтгүй үлдээх, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ хянах чадваргүй болсны улмаас гэмт хэргийн золиос болох, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна орчны хяналтын камер стандартын шаардлага хангахгүй байх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байгаагаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар хулгайлах гэмт хэрэг нийт 30029 бүртгэгдсэнээс Орхон аймагт 705 бүртгэгдсэн нь хангайн бүсэд үйлдэгдсэн тухайн төрлийн гэмт хэргийн 24,4 хувийг, Орхон аймагт үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 27.0 хувийг, улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар залилах гэмт

хэрэг нийт 36853 бүртгэгдсэнээс Орхон аймагт 628 бүртгэгдсэн нь Орхон аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн 24.2 хувийг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт 38633 бүртгэгдсэнээс Орхон аймагт 1049 бүртгэгдсэн нь хангайн бүсэд үйлдэгдсэн тухайн төрлийн гэмт хэргийн 20.7 хувийг, Орхон аймагт үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 32.5 хувийг, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг сүүлийн 5 жилд нийт 5397 бүртгэгдсэнээс Орхон аймагт 117 бүртгэгдсэн нь Орхон аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.5 хувийг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг улсын хэмжээнд сүүлийн 5 жилд 1074 бүртгэгдсэнээс Орхон аймагт 89 бүртгэгдсэн нь Орхон аймагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3.4 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийтлэг бүртгэгддэг гэмт хэргийн гаралтын судалгаа



Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн дунджаар жилд:

- Хулгайлах гэмт хэрэг 6006
- Залилах гэмт хэрэг 7371
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7727
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1079
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 123 бүртгэгдсэн байна.

Орхон аймагт сүүлийн 5 жилийн дунджаар жилд:

- Хулгайлах гэмт хэрэг 141
- Залилах гэмт хэрэг 126
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 210
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 23

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 13 бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улс болон аймаг, нийслэл, улсын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд олон талт арга хэмжээг зохион байгуулах замаар гэмт хэрэг, зөрчлийн гаралт, учрах нийгмийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн томоохон зорилтыг дэвшүүлэн хөтөлбөр боловсруулан ажиллах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Иймд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 “Тухайн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, боловсруулж, биелэлтийг хангах” заалт болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Орхон аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн криминологийн судалгааны үр дүнд уялдуулан тулгаварлан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулан ажиллаа.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1.Хөтөлбөрийн зорилго

2.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий албан тушаалтны эрх зүйн боловсролыг дээшлүүлж гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг таниулах, тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зорилтуудыг хангана. Үүнд:

2.2.1.Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

2.2.2.Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах, холбогдох арга хэмжээг нэмэгдүүлэх;

2.2.3.Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах;

2.3.Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2024-2027 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах зорилтын хүрээнд:

3.1.1.Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг соён гэгээрүүлэх арга хэмжээг уламжлалт болон шинэлэг хэлбэрээр зохион байгуулах;

3.1.2.Цэцэрлэг, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, зохих түвшний эрх зүйн мэдлэгийг олгох, боловсролын сургалтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх,

3.1.3.Дээрх төрлийн сургалтыг Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулах, суралцагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох явдлаас урьдчилан сэргийлэхэд Цагдаа, Прокурор, Шүүхийн Тамгын газар, Өмгөөлөгчдийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагаас сэрэмжлүүлэн гаргасан гэмт хэргийн хор хөнөөлийн талаарх бодит үйл баримтыг үндэслэн холбогдох сургалтыг зохион байгуулж хэвших;

3.1.4.Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, мөн хүүхэд хамгааллын чиглэлээр Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгүүдийн орчинд эцэг эхийн эргүүл буюу сургууль, цэцэрлэгийн цагдааг тогтмол ажиллуулах, Ерөнхий боловсролын сургуулийн нэгэн адил цэцэрлэгийн орчинд цэцэрлэгийн цагдаагаар ажиллах эцэг эхчүүдийг төрийн болон төрийн бус байгууллагууд тухайн эргүүлд ажилласан өдөр нь цалинтай чөлөө олгодог системд шилжүүлэх;

3.1.5.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас гаргасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн байгууллагууд хэрэгжүүлэх талаар салбар төлөвлөгөө гаргах, түүний биелэлт, үр дүнг тооцох, ажилтан, алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох зэрэг соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

3.1.6.Хуулийн этгээдийн оролцоотойгоор тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд нь дотооддоо зохион байгуулах, үйл ажиллагаа явуулж байгаа байршил, түүний ойр орчимд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа гаднах талбайн стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник хэрэгслийг нэгдсэн сүлжээнд холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих, архи согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжүүд гэрээт харуул хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, биечилсэн харуул хамгаалалттай болгох талаар зохих арга хэмжээг авах;

3.1.7.Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, түүнчлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль тогтоомжид зааснаас өөрөөр хэрэглэх, бэлтгэх, хадгалах, худалдан борлуулах зэрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн бус байгууллага, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;

3.1.8.Гамшгаас хамгаалах, галын аюулгүй байдлын талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сургалтын арга хэмжээ зохион байгуулах.

3.2.Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах, холбогдох арга хэмжээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1.Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд техник, тоног төхөөрөмжийн

шинэчлэлд тодорхой дэмжлэг үзүүлэх, холбогдох албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах;

3.2.2.Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтмол судалж, тандах тэдгээрийг арилгах арга хэмжээ авах;

3.2.3.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинэлэг олон нийтэд шинэлэг, хүртээмжтэй байдлаар арга хэмжээг зохион байгуулсан иргэн, хуулийн этгээдийг дэмжих, урамшуулах;

3.2.4.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх төрөл бүрийн нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, биелэлт, үр дүнг тооцож урамшуулах;

3.2.5.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл болон гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтээс хүлээн авдаг тогтолцоог сайжруулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр төлөвлөж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс төлбөртэй авах;

3.2.6.Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа хяналтын камерын үйл ажиллагаанд видео удирдлагын нэгдсэн систем болон дүрс бичлэгт боловсруулалт, аналитик хийх программ хангамжийг нэвтрүүлэх, барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглагдаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник хэрэгслийг теле-хяналтын нэгдсэн сүлжээнд стандартын дагуу холбох.

3.3.Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилтын хүрээнд:

3.3.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сууц өмчлөгчдийн холбоо, хөршийн холбоо, баг, бүлгийн нөхөрлөл, иргэдийн хамтын оролцоог нэмэгдүүлэх дэмжих, урамшуулах;

3.3.2.Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.3.Залилах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.4.Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийг түүхий эдийг хууль тогтоомжид зааснаас өөрөөр ашиглах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.6.Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.7.Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн цуврал нэвтрүүлэг, гарын авлага зэргийг бэлтгэх, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хүргэх, тогтмол мэдээлэл өгөх, зайлшгүй шаардлагатай хэлцэл хийх үед мэргэжлийн хуульчийн зөвлөгөөг авах;

3.3.8.Шинэ төрлийн болон техник технологийн дэвшлийг ашиглан гэмт хэрэг мөрдөх, тоон нотлох баримт цуглуулах, нотлох ажиллагааны үед гарах зардал болон албан хаагчийг сурган дэдлагажуулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэхэд зохих дэмжлэг үзүүлэх;

3.3.9.Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөн цахим гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.10.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг теле камерын хяналтаар тодорхойлох, зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягаар торгуулийн хуудас хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3.11.Аймгийн нутаг дэвсгэрийн авто замуудад улсын дугаар илрүүлэгчтэй хяналтын камер суурилуулах ажлыг нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах;

3.3.12.Гэрэлтүүлэгтэй явган хүний гарцыг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.3.13.Орон нутгийн авто замын тэмдэг, тэмдэглэлд хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангаагүй тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх ажлыг зохион байгуулах;

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Хөтөлбөрийн үр нөлөө:

4.1.1.Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ;

4.1.2.Гэмт хэргийн илрүүлэлт өсөн нэмэгдэж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо сайжирна;

4.1.3.Өсөлттэй байгаа гэмт хэргүүд буурч, хэргийн илрүүлэлт сайжирна;

4.1.4.Гэмт хэргийн гаралтыг тогтмол бууруулж, нөхөн төлөлтийн хэмжээг нэмэгдүүлнэ;

4.1.5.Аймгийн хэмжээнд тодорхой хугацаанд криминологи судалгаа хийснээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлох зэрэг сайн үр нөлөө үзүүлнэ.

4.2 Хөтөлбөрийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2018-2023 оны жилийн дундаж үзүүлэлт) | Хэмжих нэгж | Хүрэх түвшин 2024 он | Хүрэх түвшин 2025 он | Хүрэх түвшин 2026 он | Хүрэх түвшин 2027 он |
|---|----------------------|---|-------------|---------------------------------|---------------------------------|---------------------------------|---------------------------------|
| 1 | Хулгайлах гэмт хэрэг | 170 | Хувь | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 3%-аас доошгүй хувиар бууруулах | 7%-аас доошгүй хувиар бууруулах |
| 2 | Залилах гэмт хэрэг | 120 | Хувь | 1,5%-аас доошгүй | 2%-аас доошгүй | 2.5%-аас доошгүй | 6%-аас доошгүй |

| | | | | хувиар бууруулах | хувиар бууруулах | хувиар бууруулах | хувиар бууруулах |
|---|---|--|------|---|---|---|---|
| 3 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 208 | Хувь | 1,5%-аас доошгүй хувиар бууруулах | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 5.5%-аас доошгүй хувиар бууруулах |
| 4 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах | 22 | Хувь | 1,5%-аас доошгүй хувиар бууруулах | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 2.5%-аас доошгүй хувиар бууруулах | 6%-аас доошгүй хувиар бууруулах |
| 5 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 15 | Хувь | 1,5%-аас доошгүй хувиар бууруулах | 1.5%-аас доошгүй хувиар бууруулах | 2%-аас доошгүй хувиар бууруулах | 5%-аас доошгүй хувиар бууруулах |
| 6 | Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээний болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд оролцсон иргэд, хуулийн этгээдийн тоо | 20 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1088 иргэн, ГХУС-х ажилд 36 хуулийн этгээд хамтран оролцсон. | Тоо | 20-оос доошгүй удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1300-аас доошгүй иргэн, ГХУС-х ажилд 40-өөс доошгүй хуулийн этгээд хамтран оролцуулах | 20-оос доошгүй удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1300-аас доошгүй иргэн, ГХУС-х ажилд 40-өөс доошгүй хуулийн этгээд хамтран оролцуулах | 20-оос доошгүй удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1300-аас доошгүй иргэн, ГХУС-х ажилд 40-өөс доошгүй хуулийн этгээд хамтран оролцуулах | 20-оос доошгүй удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1300-аас доошгүй иргэн, ГХУС-х ажилд 40-өөс доошгүй хуулийн этгээд хамтран оролцуулах |
| 7 | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлтийг нэмэгдүүлэх (нөхөн төлөлтийн хувь) | 47.9% | Хувь | 48% | 48.5% | 49% | 50% |
| 8 | Хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэх | 1 | Тоо | | 1 | | 1 |

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ТАЙЛАГНАЛТ

5.1.Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.1.1.Улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2.Олон улсын байгууллага, хандивлагч байгууллагын зээл, тусламж, төслийн хөрөнгө;

5.1.3.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

5.1.4.Бусад хөрөнгийн эх үүсвэр;

5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, санхүүжүүлнэ.

5.3.Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу зарцуулж, тайлагнана.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцан зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанаар баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг салбар зөвлөлийн гишүүд хангаж, ажлын үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан танилцуулна.

6.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслэн шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1.Уг хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, үнэлгээг хоёр жилд нэг удаа хийлгэнэ.

7.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн тайланг холбогдох байгууллагуудад хүргэж, мөн цахимаар мэдээлнэ.